

Др. Ж.Энхсайханы хийсэн ярианы гол санаа  
(10 сарын 18-ны өдөр)

### 1. Солонгосын хойгийн асуудал

- Ихэнхи мэдээ, мэдээллийги интернетээс олж авч болно. Гэхдээ ЗААВАЛ мэдэж байх хэдэн зүйлийг хэлье. Цаад учир начирьг мэдэх хэрэгтэй байдаг.

- Эртний түүхтэй Солонгос улс яагаад хуваагдмал улс бий болсон. Японы колони. 3 сарын 1-ний хөдөлгөөн. Дайнд Япон ялагдсан. 1950-53 оны Солонгосын дайнд АНУ 36 мянган хүнээ, Өмнөд Солонгос 217 мянган хүнээ, БНАСАУ 406 хүнээ, Хятад /600 мянган хүнээ алуулсан байдаг.

Солонгосын стратегийн ач холбогдол. 1950-53 онд 2 хуваагдсан. Өмнөд Солонгос илүү хүн амтай, АНУ-ын холбоотон, Хойд Солонгос - ЗХУ, Хятадын холбоотон.

БНАСАУ: 25 сая хүн амтай, 30 тэр бум долларын эдийн засагтай, 1.1 саяын армитай, хөгжиж байгаа орон. Нэг хүнд оногдох үндэсний орлого– 1.800 ам доллар.

Өмнөд Солонгос: 51 сая хүн амтай, 1, 7 их наядын эдийн засагтай (өөрөөр хэлбэл БНАСАУ-ынхаас бараг 60 дахин их). Арми: 600.000. Үйлдвэр хөгжсөн, их 20—ын нэг. Нэг хүнд оногдох үндэсний орлого 37.000 ам доллар. Эдийн засгийн хэмжээгээрээ ОХУ-ын дараа ордог.

Солонгосын дайны үед АНУ БНАСАУ-ыг, нэн ялангяа Пхеньяныг их хүчээр бөмбөгдсөнийн дээр цэргийн команлагч нь цөмийн зэвсэг хэрэглэхээр сүрдүүлж байсан. Тиймээс 1950-иад оны дунд үеэс БНАСАУ цөмийн зэвсэгтэй болох талаар бодож эхэлсэн. Нөгөөтэйгүүр Өмнөд Солонгос АНУ-ын холбоотныхоо хувьд түүний цөмийн шүхэр дор “хамгаалагдсан” байсан. Өмнөд Солонгосын нийслэл хилд нэлээн ойрхон, их бууны сум тусах зайнд байдаг нь түүний геополитикийн нэн сул тал байв. Хүйтэн дайны төгсгөлөөр, БНАСАУ холбоотонгүй болохоороо өөрийн гэсэн цөмийн зэвсэгтэй болохоор хатуу шийдсэн. БНАСАУ ЗХУ-ын туслалцаатайгаар бага оворын ЦЦС-тай болсон бөгөөд түүнээс гарах ашигласан түлшээс плутонийг нь авч цөмийн цэнэг толгой хийдэг болсон. Дараа нь мөн ураныг баяжуулж цөмийн цэнэг толгой хийх боломжтой болсон байдаг.

БНАСАУ цөмийн зэвсэгтэй болохын уршиг, өр дагаварыг\_ тайлбарлах. 6 талт хэлэлцээ яагаад тодорхой амжилтан хүрээгүйг талбарлах.

1984 оноос хойш 114 удаа уужигаа туршиж, 2006 оноос хойн 6 удаа цөмийн зэвсгээ туршив Ноднин жил тив алгасагч балистик пуужингаа туршиж АНУ шууд заналхийлэх боломжтойгоо харуулав. Мөн туршилтууд нь Япон, Өмнөд Солонгост шууд заналхийлэх болов. АНУ эхлээд үл тоож, дараа нь айлгаж сүрдүүлээд хөтөлбөрийг нь зогсоож чадаагүй, байдал улам хурцдав. Түүний болзошгүй үр дагаварыг тайлбарлах.

Ким Жэ-уны *шинэ жилийн үг*: эдийн засагт анхаарна.

Өмнөд Солонгос их түгших болов. Мун Жэй-иний Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын гол зорилтыг тайлбарлах. Байдлыг намжаах бодлого явуулах болов. БНАСАУ-ын гол хөшүүрэг: цөмийн зэвсгээ хорогдуулан устгах, харилцаагаа хэвийн болгох, нэн түрүүнд АНУ-тай.

Яриа хэлэлцээ одоо явагдаж эхэлж байна. Хэдийгээх БНАСАУ цөмийн зэвсгээ хорогдуулан устгаж болох талаар дурдсан боловч тэгэхийн тулд тавьж буй урьдчилсан нөхцөл тавив. Түүнийг нэг бүрчлэн тайлбарлах.

CVID (хатуу хяналтын дор бүрэн, эргэж буцалгүйгээр хураах) vs. Korean peninsula (US bases...)-ын ялгааг тайлбарлах. БНАСАУ яриа хэлэлцээ хийхэд яарахгүй, залуу удирдагчтай байгаа. Харин АНУ-ын улс төрийн календарь нь 3-4 жил байдаг нь тэндий сул тал юм. Мөн хоёр нам өрсөлддөг тул тогвортой, тууштай нэг бодлого барьдаггүй.

Сингапурын дээд хэмжээний уулзалт, түүний нааштай болон сул талыг тайлбарлах. Цаашид үйл явдал хэрхэж өрнөж болох 3 хувилбарыг тайлбарлах.

Монгол Улсын байр суурь боломжийн оролцоог тайлбарлах. Улаанбаатарын яриа хэлэлцээ нь итгэлцэлд дөхөм үзүүлэх зорилготой. Улаанбаатарын үйл явц, түүний ач холбогдлыг тайлбарлах.

## **2. ЕврАзийг холбосон бизнесийн орон зайд эдийн засгийн хамтын ажиллагааны шинэ загвар цогцлох нь**

ЕврАзийн Холбоо гэж юу вэ ? ЕврАзийн орон зай - 2012 онд, ЕврАзийн Холбоо - 2014 оноос. Зорилго, товч түүхийг тайлбарлах. Бараа, хөрөнгө, үйлчилгээ, хүн ам чөлөөтэй зорчих орон зайг аажмаар тэлж нэгдмэл зах зээл болгохыг ОХУ зорьж байгаа. Эхний 3 – Орос, Беларусь, Казахстан. Дараа нь Армени, Кыргызстан нэгдэж оров. Украин анх судалж байгаад больсон. Энэ жил Иран чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж 350 нэр төрлийн барааг гаалийн татваргүй гаргаж, 180 барааг импортолно. ЕврАзийн холбоонд нэгдэж орох нөхцөл: нэгдэж орвол – урьд өмнө байгуулсан гэрээ хэлэлцээрүүдийг мөрдөнө.

ЕврАзийн бүсийн тухай тоон хэллэгээр:

- 183 сая хүн ам - 1.5%
- Газар нутгийн 15%
- Байгалийн хийн - 20%

- Газрын тосны 15%
- 2.2 тэр бум долларын эдийн засагтай. World GNP – 2.5%.

Анх Назарбаев 1994 онд санал тавьж байсан. Ельцин тоогоогүй. Аажмаар яригдаж байгаад Крымийн асуудал, барууны эдийн засгийн хоригийн дараа түргэсэв. Ег. байгалийн хийн хоригоос болж Орос Хятадад 400 тэр бум долларын хий нийлүүлэхээр болсон. Монголын хоёр талаар хоолой татагдаж байгаа.

ЯВААНДАА: макроэдийн засгийн, тээврийн, үйлдвэр-хөдөө аж ахуйн, эрчим хүчний, худалдаа, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, ...нэгдсэн нэг валют (Алтын), мөнгөний, төлбөр тооцооны *visa, master card*-ын адил тооцоо хийх механизм, улс төрийн, цэргийн болон соёлын нэгдсэн бодлогтой болох. Тэгэх нь манай улсад ашигтай юу? Сайтар бодох хэрэгтэй. Казахстан одоо эргэлзэж эхэлсэн. Путин дургүйцлээ илэрхийлж, ЗХУ байгуулагдтал казахууд бие даасан улс байгаагүй гэж хэлсэн. Цаашид энэ зөрчил нэмэгдэж болзошгүй байна.

МОНГОЛ – сайтар бодож тооцоолох хэрэгтэй. Ноднин 10 сард хоёр талын уулзалт УБ-т болсон. ЕврАзийн эдийн засгийн Комисс. Манай одооны гол зорилго бол тарифыг бууруулж тарифын бус (шошго, ариун цэвэр, г.м.) хоригийн нөхцлийг аажмаар арилгах явдал юм. Судлах, хамтарч ажилла, бусадын туршлагыг судлаад шийдвэрээ гаргах.

Эцсийн бүлэгт – хил залгадгаар нь ОХУ-тай нарийн ярилцах хэрэгтэй болно. Манай ХАА-н бүтээгдэхүүн 15-25 %-ийн татвар, онцгой татвар – 12-20 % татвартай байгаа. Сүүлийн 40 жил ийм байгаа.

2015 онд харилцан ойлголцох меморандумд гарын үсэг зурж хамтын ажиллагааны агуулгын талаар ярилцаж тохирхоор болсон.

#### БОДОЛЦОХ НЬ:

- Ноолуур, савхин болон нэхмэл эдлэл нэмүү өртөг, гааль, онцгой татвар нийлээд 39%-ийн татвар төлж буй. Хир буурах вэ? Ямар наймаа байж болох вэ ?
- Үр тариа, гурилын хувьд гэвэл ОХУ #3. Тиймээс бид дотоодынхоо үйлдвэрлэгчдийг хамгаалж чадах уу ?
- Хөвөн, бөс барааг Узбекээс авах нь илүү хямд болох нь Хятадын монополиос гарч чадах уу ?
- Японтой байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээрийн биелэлт тааруу. Манай стандарт доогуур, ариун цэвэр, баглаа сав нь гологдож байна.
- Нэг ахиц – ОХУ транзит тээврийн олон улсын тарифыг 25 жил 40 %-иар хөнгөлөв. Нүүрсний тээврийн тарифыг – 60%-иар хөнгөлөв.

- ХЯТАДТАЙ – ерөнхий хэлэлцээр байгуулсан, барааг шилжүүлэн ачих шинэ төрөөрөмжтэй болсон. Одоо гаалийн үзлэг, транзит тээвэр, барааг ачиж буулгах тарифыг хэлэлцэж тохирох хэрэгтэй байна.